



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН АЛБА



**МӨНГӨ
УГААХ БОЛОН
ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ**

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН АЛБА



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ

Улаанбаатар хот
2025 он

1

МӨНГӨ УГААХ

МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?

Гэмт хэрэг үйлдэж хууль бусаар олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж эдийн засгийн эргэлтэд оруулж "бохир" мөнгийг "цэвэр" буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг юм.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулинд зааснаар **"МӨНГӨ УГААХ"** гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.



МӨНГӨ УГААХ НЬ ИХЭВЧЛЭН ДАРААХ ҮНДСЭН ЗОРИЛГОТой БАЙДАГ. Үүнд:

- Хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгийг өөрчлөн, шилжүүлэх;
- Хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгө болон эзэмшигчийг нь нуун далдлах;
- Хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах, үр шимийг нь хүртэх;

Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, зөвлөгөө өгөх гэх мэт.

МӨНГӨ УГААХ ТҮГЭЭМЭЛ СУУРЬ ГЭМТ ХЭРГҮҮД:



Хууль бус галт зэвсгийн наймаа



Хүний эд, эрхтний наймаа



Хар тамхины худалдаа



Бусдын биеийг үнэлүүлэх



Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдвэрлэх



Авлига, хээл хахууль



Татвараас зайлсхийх



Байгаль орчны эсрэг гэмт хэрэг



Хулгай




Дээрэм

Мөнгө угаах үйл ажиллагаа нь байршуулах, нуун далдлах, буцаан төвлөрүүлэх гэсэн дараах 3 шаттай үйлдэгддэг.

1

БАЙРШУУЛАХ



"Бохир" мөнгийг санхүүгийн системд байршуулах

Хууль бус орлогыг хууль хяналтын байгууллагын анхаарлыг таталгүйгээр санхүүгийн системд нэвтрүүлж, анхны эх үүсвэрээс "салгах" явдал юм.

2

НУУН ДАЛДЛАХ




Олон төрлийн гүйлгээ хийж эргэлдүүлэх

Хууль бусаар олсон хөрөнгийг эх үүсвэрээс нь холдуулах зорилгоор эргэлзээ төрүүлж, олон төрлийн ээдрээтэй гүйлгээ хийж эргэлдүүлэх үйл явц юм.

3

БУЦААН ТӨВЛӨРҮҮЛЭХ



Эд хөрөнгө, санхүүгийн хөрөнгө оруулалт руу шилжүүлэх

Тансаг зэрэглэлийн хөрөнгө, санхүүгийн хөрөнгө оруулалт, худалдаа болон үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт руу шилжүүлэх явц юм.

2

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зааснаар **"ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ"** гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх нь мөнгөний гарал үүсэл, зорилго, сэдлээрээ ялгаатай ч мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах болон байршуулах арга хэлбэрээрээ ижил төстэй. Терроризмыг санхүүжүүлэх **үе шат** дараах хэлбэртэй байна.

1

ХӨРӨНГӨ БОСГОХ



2

ХӨРӨНГИЙГ ШИЛЖҮҮЛЭХ



3

ХӨРӨНГИЙГ ХЭРЭГЛЭХ



Хандив, тусламж, нийтийн сүлжээ, хууль бус болон хууль ёсны орлого

Хил нэвтрүүлэх, мөнгөн гуйвуулга хийх, төлбөр тооцооны хэрэгсэл ашиглах

Террорист ажиллагааг зохион байгуулах, зэвсэг худалдан авах

Мөнгө угаах гэмт хэргийн арга хэлбэр нь терроризмыг санхүүжүүлэхтэй ижил төстэй явагддаг тул **ЭНЭ хоёр гэмт хэргийг нягт холбодог**. Гэвч агуулгын хувьд энэ хоёр нь тусдаа явагддаг. Тухайлбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харуулахыг зорьдог байхад терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны орлогоор ч бас санхүүжиж болдог.

01

МӨНГӨ УГААХ

Хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харагдуулахыг зорьдог.

02

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Хууль ёсны болон хууль бус орлогыг террорист үйл ажиллагаанд зарцуулахыг хэлдэг.

ТЕРРОРИЗМЫГ ИХЭВЧЛЭН ДАРААХ ЭХ ҮҮСВЭРЭЭС ОЛСОН ОРЛОГООР САНХҮҮЖҮҮЛДЭГ. ҮҮНД:



Луйвар, залилан хийх



Хүн барьцаалах, хулгайлах



Хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах



Цахим мөнгөөр хууль бус худалдаа хийх



Ашгийн бус байгууллагыг буруугаар ашиглах



Газрын тос, нүүрс алмаз, алт зэрэг бараагаар хууль бус худалдаа хийх



Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх гэж Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд зааснаар "Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх зорилгоор хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүнийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг" хэлнэ гэж заажээ.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх нь хүний амь нас, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, цаашлаад олон улсын энх тайван, аюулгүй байдалд ноцтой хор уршиг учруулж байна. Террорист байгууллага, бүлэглэл болон бусад этгээдийн зүгээс түүнийг олж авахыг эрмэлзэж байгаа нь эрсдэл дагуулж байна. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхэд тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэхээр зэхэж буй этгээдүүдтэй холбоотой аливаа санхүүгийн урсгалыг таслан зогсоох нь чухал ач холбогдолтой юм.

3

БИД ЯАГААД МЭДЭХ ЁСТОЙ ВЭ?

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь эдийн засаг, нийгэмд өндөр хор уршигтай байдаг. Хамгийн энгийн жишээ гэвэл хэрэв хууль бус их хэмжээний хөрөнгө манай улсын санхүүгийн системээр угаагдаж байвал нэн түрүүнд санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул учруулдаг. Хууль бус хөрөнгө нь дотоодынх бол авилга хээл хахуулийг ихэсгэх, шудрага өрсөлдөөнийг үгүй хийнэ.

Мөн олон улсын тавцанд улс орны нэр хүндийг унагахаас гадна тухайн улсын санхүүгийн систем, цаашлаад улс үндэстэнд итгэх итгэлийг үгүй хийх ба олон улсын санхүүгийн системд эрсдэлтэй гэж үзэгдэн аливаа хаалт, шахалтад орж эдийн засаг тэлэх боломж хумигдах, тухайн улсын иргэдийн өдөр тутмын амьдралд нөлөөлдөг байна.





МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН НИЙГМИЙН ХОР НӨЛӨӨ:

- Үлэмж хэмжээний эд хөрөнгө эдийн засгийн үндэслэлгүй улс дамнан шилжих нь зарим улс орон, тэр ч бүү хэл бүс нутгийн санхүү, эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд асар их хор уршигтай.
- Хууль ёсны эргэлтэнд орж угаагдсан мөнгө зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, терроризмын санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх үржил шимтэй хөрс нь болдог.
- Шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагддаг.
- Санхүүгийн байгууллагын хүчин чадлыг доройтуулдаг.
- Улсын төсөвт орох орлого буурч, татвараа шударгаар төлөгч иргэдийг хохироодог.

САНХҮҮГИЙН ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ АВАХ БАЙГУУЛЛАГА /ФАТФ/

ФАТФ нь олон улсын санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс сэргийлэх бодлого боловсруулж, дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын, хараат бус байгууллага.

Монгол Улс ФАТФ-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн бөгөөд Монгол Улсын тогтолцоонд 2007, 2017 онуудад харилцан үнэлгээг хийсэн. Үнэлгээний үр дүн хангалтгүй гарснаар Монгол Улс 2013, 2019 онд ФАТФ-ын **"саарал"** жагсаалт буюу мөнгө угаах өндөр эрсдэлтэй улс орнуудын жагсаалтад орсон юм.

Иймд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо хангалтгүй байснаар санхүүгийн гадаад шилжүүлэг, гүйлгээ удаашрах, үнэ өсөх, зээл авах нөхцөл чангарах, ажлын байр хомсдох, орлого буурах зэргээр иргэдийн амьдралд сөрөг нөлөө үзүүлдэг.

"Саарал" жагсаалтад орсноор үүсэх сөрөг үр дагаврууд:

- Олон улсын санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид Монголд итгэх итгэл буурч, хөрөнгө оруулалт буурах;
- Санхүүгийн байгууллагууд олон улсын банк санхүүгийн сүлжээнээс тусгаарлагдах, мөнгөн гүйлгээ удаашрах;
- Улс орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх гэх мэт.



4

ТҮГЭЭМЭЛ МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГҮҮД

Монгол Улсад гарч буй мөнгө угаах төрлийн гэмт хэрэг нь дараах аргаар үйлдэгдэж байна гэж үзэж байна:

- Гэмт хэргийн замаар олсон орлогоо гадаадын банканд дахь дансанд шилжүүлэх, ингэхдээ гэмт хэрэгтүүд өөрсдийн гэр бүл, эцэг, эх, ах дүү, хамаатан садан, ойр дотныхоо хүний нэр дээрх дансанд гуйвуулах;
- Гадаадын иргэд "бохир" мөнгөө Монголд оруулж ирэхдээ уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийх халхавчаар оруулж ирэн, буцааж гаргах;
- Үнэт металл худалдан авч, хууль бусаар Монгол Улсын хилээр гарган, олсон хууль бус орлогоо буцаан оруулж ирж, эргэлтэнд оруулах;
- Төрийн зарим албан хаагчид албан тушаалын байдлаа урвуулан ашиглан, хээл хахуулийн журмаар олсон хууль бус орлогоо гадаад, дотоодын банкны тогтолцоогоор дамжуулан хууль ёсны мэт болгохыг оролдох;
- Төрийн өмчит компаний удирдлагад ажиллаж байсан зарим хүмүүс албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хуурамч гэрээ байгуулан, хөрөнгө мөнгийг гадаадын хэд хэдэн улс руу гарган, буцааж оруулж ирэх;



- Хууль бус орлогоо барилга, үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулж, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, барилга барих зэргээр хөрөнгө оруулалт хийж, орлогоо хууль ёсны хэлбэрт шилжүүлэх;
- Сүүлийн жилүүдэд криптовалют бий болсноор мөнгө угаах гэмт хэргийн шинэ хэлбэрийг үүсгэсэн ба криптовалютаар хийх гүйлгээг нууц нэрээр гүйцэтгэснээр хөрөнгийн хууль бус гарал үүслийг нуун дарагдуулах үр дүнтэй арга зам болж байна.

5

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Мөнгө угаах гэмт хэрэгт хэн ч өртөх боломжтой байдаг. Иргэн та энэ төрлийн гэмт хэргийн үйлдэлд мэдлэг мэдээлэл дутмагаас болж мэдэлгүй оролцох, мэдэх боломжтой байсан боловч өнгөрүүлэх зэрэг тохиолдол гарч болно. Мөн мөнгө угаахаар зорьж буй этгээд нь "бохир мөнгө"-ийг хамгийн түрүүнд **санхүүгийн болон санхүүгийн бус салбарын байгууллага, этгээдээр дамжуулан эх үүсвэрийг далдлахыг зорьдог.** Энэ эрсдэлээс сэргийлэх, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхээр эдгээр байгууллага этгээдийг "Мэдээлэх үүрэгтэй этгээд" гэж үзэн хуулийн дагуу тодорхой эрх, үүргийг олгосон байдаг.





Иргэн та дараах төрлийн байгууллагуудаар үйлчлүүлж байгаа бол тухайн байгууллагуудын шаардаж байгаа мэдээлэл болон баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй. Үүнд:

- Банк;
- Банк бус санхүүгийн байгууллага;
- Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;
- Хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;
- Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;
- Хадгаламж, зээлийн хоршоо;
- Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;
- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;
- Нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч;
- Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч;
- Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд;



Хэрэв та эдгээр байгууллагын шаардсан мэдээлэл болон баримт бичгийг гаргаж өгөхөөс татгалзвал дээрх мэдээлэх үүрэгтэй этгээдүүд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн **5.4**-т зааснаар **танд** үйлчилгээ үзүүлэхээс татгалзах эрхтэй.

Эдгээр мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу дараах **мэдээллийг мэдээлэх үүрэгтэй**. Үүнд:

- 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй **бэлэн мөнгөний гүйлгээ**;
- 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй **гадаад төлбөр тооцооны гүйлгээ**;
- 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй **виртуал хөрөнгийн гүйлгээ**;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого бүхий **сэжигтэй гүйлгээ** /дүн харгалзахгүй/.

ХЭРВЭЭ ТАНД МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ БАЙГАА БОЛ ХЭНД ХАНДАХ ВЭ?

Танд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбоотой гэж үзэж байгаа мэдээлэл байвал дараах зохицуулах болон хууль сахиулах байгууллагуудад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.



МОНГОЛБАНКНЫ ДЭРГЭДЭХ
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

- + (976) 11 326161
- Монгол Улс, Улаанбаатар хот, Бага тойруу-3, 15160
- fiu@mongolbank.mn



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ
САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АЛБА

- + (976)-51-264444, +(976)-70137047 (МУТСТ алба)
- Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр, 15160
- info@frc.mn



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

- + (976)-51-265734, +(976)-51-265794
- Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо Самбуугийн гудамж-18. Эрүүгийн цагдаагийн алба



ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

- + (976)-92263017
- Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж-3
- amlcft@gia.gov.mn; nctcc@gia.gov.mn



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

- + (976)-110 (Үнэ төлбөргүй)
- Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороолол, Сөүлийн гудамж, 41
- contact@iaac.mn

